



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/020/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
	Аудитор: Ц.Чагнаадорж Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn
	“Си Пи Ти Эй Аудит” ХХК-ийн захирал: Ч.Энхчимэг Утас: 99046494 Цахим хаяг: enkhchimeg@cptaaudit.mn
Хөвсгөл аймаг 2026 он	Гүйцэтгэсэн аудитор: М.Мөнхтөгс Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/2023
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ОТГОННЯМ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар нийт 3,183.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэсэн байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бараа материалын тооллоготой холбоотой 1 албан шаардлага, төсвийн төлөвлөлт болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 2 зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын газрын даргаар батлуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 91.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>235,399,120.95</u>	<u>170,219,421.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,753,745.25	36,589,696.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	107,753,745.25	36,589,696.82
3121	Төгрөг	107,753,745.25	36,589,696.82
31211	Төрийн сангийн харилцах	107,753,745.25	36,589,696.82
33	АВЛАГА	00.00	838,736.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	838,736.75
35	БАРАА МАТЕРИАЛ	127,645,375.70	132,790,988.28
351	Түүхий эд материал	610,830.00	81,000.00
35130	Эм боох материал	610,830.00	81,000.00
354	Хангамжийн материал	127,034,545.70	132,709,988.28
35410	Бичиг хэргийн материал	2,127,350.00	11,052,140.00
35420	Аж ахуйн материал	52,598,402.00	57,054,115.00
35440	Түлш, шатах тослох материал	29,856,265.00	33,108,594.58
35450	Барилгын засварын материал	3,071,300.00	230,500.00
35460	Хүнсний материал	17,812,730.00	5,983,440.00
35470	Бусад хангамжийн материал	21,568,498.70	25,281,198.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>555,847,228.01</u>	<u>526,529,204.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	555,847,228.01	526,529,204.55
392	Биет хөрөнгө	541,235,228.01	511,917,204.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	555,962,753.40	555,962,753.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-115,383,840.72	-131,589,087.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,231,420.00	92,059,820.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,985,785.57	-54,259,362.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,357,905.14	64,068,290.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,521,771.61	-49,142,457.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,727,060.00	64,727,060.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-21,583,906.47	-32,341,204.99
39217	Ном	2,431,393.84	2,431,393.84
393	Биет бус хөрөнгө	14,612,000.00	14,612,000.00
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,612,000.00	14,612,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>791,246,348.96</u>	<u>696,748,626.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>993,943.00</u>	<u>228,127.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	993,943.00	228,127.00
413	Өглөг	993,943.00	228,127.00
4136	Бусад өглөг	993,943.00	228,127.00

41361	Байгууллагад төлөх өглөг	993,943.00	228,127.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	790,252,405.96	696,520,499.40
51	Засгийн газрын хувь оролцоо	790,252,405.96	696,520,499.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	88,908,550.46	88,908,550.46
51101	Өмч: - төрийн	88,908,550.46	88,908,550.46
512	Хуримтлагдсан үр дүн	666,726,230.68	572,994,319.12
51210	Өмнөх үеийн үр дүн	666,726,230.68	666,726,225.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-93,731,906.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,617,624.82	34,617,629.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	791,246,348.96	696,748,626.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	960,531,187.00	1,035,473,580.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,201,287.00	39,349,780.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,201,287.00	39,349,780.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,357,287.00	39,349,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	545,000.00	140,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,812,287.00	31,123,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913,329,900.00	996,123,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,829,900.00	951,267,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	867,829,900.00	951,267,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,500,000.00	44,856,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,500,000.00	44,856,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	947,147,098.05	1,128,869,186.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,147,098.05	1,128,869,186.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	933,511,971.71	1,124,628,783.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	670,097,159.94	830,432,435.26
210101	Үндсэн цалин	430,831,538.69	492,318,891.30
210102	Нэмэгдэл	211,817,975.42	281,088,577.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	21,340,850.00
210104	Урамшуулал	27,447,645.83	35,684,116.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,808,220.74	103,519,242.42
210201	Тэтгэврийн даатгал	56,622,209.59	71,481,935.79
210202	Тэтгэмжийн даатгал	6,698,803.10	7,751,405.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,342,801.55	4,424,525.82
210204	Ажилгүйдлийн даатгал	3,017,459.29	4,372,282.16
210205	Эрүүл мэндийн даатгал	12,126,947.21	15,489,093.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,655,412.66	30,681,290.98

210301	Гэрэл, цахилгаан	9,493,862.66	12,621,653.56
210302	Түлш, халаалт	10,161,550.00	13,059,637.42
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	5,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,587,670.00	12,247,837.00
210401	Бичиг хэрэг	1,684,150.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,675,500.00	9,840,300.00
210408	Бараа материал ақталсны зардал	228,020.00	2,407,537.00
2105	Нормативт зардал	66,220,960.00	76,299,840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	66,130,960.00	75,999,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,745,000.00	9,640,800.00
210604	Урсгал засвар	15,745,000.00	9,640,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,147,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,147,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,572,500.00	1,895,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,572,500.00	1,895,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,677,448.37	59,911,437.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,437,500.00	7,997,954.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,456,400.00	5,988,410.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,783,548.37	45,925,073.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,635,126.34	4,240,403.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,635,046.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,635,046.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80.34	4,240,403.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80.34	4,240,403.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>13,384,088.95</u>	<u>-93,395,606.56</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	336,300.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	336,300.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-336,300.00
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>13,384,088.95</u>	<u>-93,731,906.56</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,908,550.46	34,617,624.82	537,734,552.10	661,260,727.38
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,908,550.46	34,617,624.82	537,734,552.10	661,260,727.38
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	64,280,216.30	64,280,216.30
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,908,550.46	34,617,624.82	666,726,230.68	790,252,405.96

D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,908,550.46	34,617,624.82	666,726,230.68	790,252,405.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-05.00	-05.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,908,550.46	34,617,624.82	666,726,225.68	790,252,400.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	05.00	00.00	05.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-93,731,906.56	-93,731,906.56
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,908,550.46	34,617,629.82	572,994,319.12	696,520,499.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>913,874,900.00</u>	<u>996,263,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	545,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	545,000.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	545,000.00	140,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	545,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913,329,900.00	996,123,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,829,900.00	951,267,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	867,829,900.00	951,267,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,500,000.00	44,856,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,500,000.00	44,856,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>896,254,330.63</u>	<u>1,065,902,848.43</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,254,330.63	1,065,902,848.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,619,204.29	1,061,662,444.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	670,097,159.94	837,746,397.60
210101	Үндсэн цалин	430,831,538.69	499,632,853.64
210102	Нэмэгдэл	211,817,975.42	281,088,577.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	21,340,850.00
210104	Урамшуулал	27,447,645.83	35,684,116.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,684,924.69	97,044,016.83
210201	Тэтгэврийн даатгал	55,933,641.18	65,502,307.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,635,350.15	7,751,405.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,317,598.03	4,424,525.82
210204	Ажилгүйдлийн даатгал	3,030,190.78	3,876,685.31
210205	Эрүүл мэндийн даатгал	12,768,144.55	15,489,093.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,499,919.66	33,615,596.56

210301	Гэрэл, цахилгаан	8,499,919.66	13,615,596.56
210302	Түлш, халаалт	18,000,000.00	15,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	55,120,000.00	63,808,770.00
210502	Хоол, хүнс	55,120,000.00	63,808,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	7,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,572,500.00	1,895,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,572,500.00	1,895,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,644,700.00	20,551,764.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,778,600.00	14,698,664.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,866,100.00	5,853,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,635,126.34	4,240,403.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,635,046.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,635,046.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80.34	4,240,403.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80.34	4,240,403.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,620,569.37	-69,639,048.43
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,394,300.00	1,525,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,394,300.00	1,525,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,394,300.00	1,525,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,394,300.00	1,525,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,394,300.00	-1,525,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,226,269.37	-71,164,048.43
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,527,475.88	107,753,745.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	107,753,745.25	36,589,696.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,038,706,800.00	951,407,800.00	87,299,000.00	91.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	948,934,100.00	951,267,800.00	-2,333,700.00	100.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	948,934,100.00	951,267,800.00	-2,333,700.00	100.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,772,700.00	140,000.00	89,632,700.00	0.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	140,000.00	-140,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	89,772,700.00	0	89,772,700.00	0

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,038,706,800.00	1,022,571,848.43	16,134,951.60	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,038,706,800.00	1,022,571,848.43	16,134,951.60	98.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,038,609,600.00	1,022,571,848.43	16,037,751.60	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,306,800.00	837,746,397.60	9,560,402.40	98.9
210101	Үндсэн цалин	538,254,100.00	499,632,853.64	38,621,246.40	92.8
210102	Нэмэгдэл	281,641,000.00	281,088,577.71	552,422.30	99.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	21,340,850.00	-21,340,850.00	
210104	Урамшуулал	27,411,700.00	35,684,116.25	-8,272,416.30	130.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,473,100.00	97,044,016.83	1,429,083.20	98.5
210201	Тэтгэврийн даатгал	66,967,900.00	65,502,307.05	1,465,593.00	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	7,879,100.00	7,751,405.52	127,694.50	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,940,900.00	4,424,525.82	-483,625.80	112.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,940,900.00	3,876,685.31	64,214.70	98.4
210205	Эрүүл мэндийн даатгал	15,744,300.00	15,489,093.13	255,206.90	98.4
2105	Нормативт зардал	63,810,100.00	63,808,770.00	1,330.00	100
210502	Хоол, хүнс	63,810,100.00	63,808,770.00	1,330.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,420,900.00	3,420,900.00	0	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,420,900.00	3,420,900.00	0	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25598700	20551764	5,046,936.00	80.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,745,600.00	14,698,664.00	5,046,936.00	74.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,853,100.00	5,853,100.00	0	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97200	0	97,200.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,200.00	0	97,200.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,200.00	0	97,200.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	107,753,745.25	-107,753,745.30	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	36,589,696.82	-36,589,696.80	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	0	100
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0	100

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,856,000.0	40,615,596.6	4,240,403.44	90.5
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,856,000.00	40,615,596.6	4,240,403.44	90.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,856,000.0	33,615,596.56	4,240,403.44	88.7

210301	Гэрэл, цахилгаан	17,856,000.0	13,615,596.56	4,240,403.44	76.3
210302	Түлш, халаалт	15,000,000.0	15,000,000.00	0.00	100
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.0	5,000,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.0	7,000,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	7,000,000.0	7,000,000.00	0.00	100

3. Аудитын илрүүлэлт

Аудитын гүйцэтгэлийн явцад 10,417.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 7,900.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 19,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүллээ.

3.1 Аудитын залруулга

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой 10,417.2 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Шинээр орлогоор авсан 3,183.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тэг гэж авсныг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт заасан ашиглалтын хугацаанд нийцүүлэн элэгдүүлж залруулав.
2. Бодогдсон цалингийн цэс, журнал бичилттэй 7,233.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

3.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.3 Албан шаардлага

1. Жилийн эцсийн бараа материалын тооллогыг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгахад, 3,737.7 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг илүү, 4,162.3 мянган төгрөгийн бараа материалыг дутуу нийт 7,900.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2.-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлага:

Жилийн эцсийн бараа материалын тооллогоор илэрсэн 7,900.0 мянган төгрөгийн зөрүүг холбогдох баримтад үндэслэн бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийж зөрчлийг арилгах

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Тайлант жилд 15.000.0 мянган төгрөгийн түлээ худалдан авснаар бараа материалын дансанд жилийн хэрэглээнээс 2 дахин илүү хэмжээгээр 33,108.6 мянган төгрөгийн үнэ бүхий 753 метр куб түлээний үлдэгдэлтэй, 2026 оны төсөвт түлшний зардалд 19,000.0 мянган төгрөгийг төлөвлөж батлуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

2026 онд түлш халаалтын зардалд төлөвлөгдсөн зардлыг бусад хэрэгцээ шаардлагатай зардалд зарцуулах саналыг төсвийн тодотголоор хэлэлцүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Шилэн дансны хөтлөлтэй холбоотой

Илрүүлэлт:

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 11,454.2 мянган төгрөгийн, орлогын 82,198.8 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" дахь заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн ил тод байдлыг хангаж, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын www.Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруул аагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шинээр орлогоор авсан үндсэн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт заасан ашиглалтын хугацаанд нийцүүлэн элэгдэл тооцоогүй	1	3,183.4					1	3,183.4		
Бодогдсон цалингийн цэс, журнал бичилттэй зөрүүтэй тайлагнасан	1	7,233.8					1	7,233.8		
ДҮН	2	10,417.2					2	10,417.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцсийн тооллого санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй таарахгүй байх	1	7,900.0			1	7,900.0						

2026 онд түлш халаалтын зардалд төлөвлөгдсөн зардлыг бусад хэрэгцээ шаардлагатай зардалд зарцуулах саналыг төсвийн тодотголоор хэлэлцүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах	1	19,000.0				1	19,000.0				
Дүн	2	26,900.0		1	7,900.0	1	19,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны системд 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний үнийн дүнтэй орлогын 82,198.8 мянган төгрөг, зарлагын 11,454.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээллээгүй орхигдуулсан	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								